

**Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгөгдсөн
үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн ажлын тайлан**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

2016.12.16

ЗТХС-ын 214 тушаалын 390 үүрэг даалгаврыг хяналтад авч, хэрэгжилтийн явцад 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналтад байгаа нийт үүрэг даалгаврын 105 нь биелсэн, 74 арга хэмжээ 90%, 48 арга хэмжээ 70%, 58 арга хэмжээ 50%, 22 арга хэмжээ 30%, 4 арга хэмжээ 10%-ийн хэрэгжилттэй, 14 арга хэмжээ хэрэгжээгүй буюу биелэлтээ ирүүлээгүй, 26 арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа болоогүй, 39 арга хэмжээ тушаалаар хүчингүй болсон, нийт 74,2 хувийн биелэлттэй байна.

ЗТХС-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/								Хүчин гүй болсон	Биелэлт хувь
			100	90	70	50	30	10	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй		
1	Дэд сайд	18	6	4	2	5	1	-	-	-	-	76.7
2	ТНБД	39	6	12	9	6	2	1	1	1	1	72.4
3	БТГ	71	19	10	12	11	6	1	3	6	3	70.6
4	ТЗУГ	27	5	7	4	6	2	1	1	-	1	68.5
5	ХШУДАГ	81	15	23	13	15	1	-	1	12	1	77.3
6	АЗБХЗГ	69	16	18	14	12	4	1	1	2	1	74.7
7	АТБХЗГ	40	12	11	5	5	1	1	2	1	2	76.5
8	ТЗДТБХЗГ	46	11	9	7	8	7	1	1	1	1	68.6
9	АТБХЗХ	35	12	4	5	8	5	-	-	1	-	72.3
10	ИНЕГ	60	16	15	6	12	1	-	-	10	-	80.0
11	ЗТХТ	44	14	12	4	4	1	-	4	1	4	76.7
12	АТҮТ	48	17	14	4	5	3	-	1	3	1	81.3
13	ГТХЗНТ	23	5	13	2	1	-	-	-	2	-	88.6
14	МИАТ	29	1	2	2	4	-	-	10	-	10	32.6
15	УБТЗ	49	6	2	1	2	1	1	18	-	18	31.9
16	МТЗ	21	3	12	4	-	-	-	1	-	1	83.0
17	Далайн захиргаа	35	11	6	4	-	-	-	6	2	6	71.1
18	НТОЗШША	15	-	3	1	-	1	-	5	-	5	37.0
19	төслийн нэгж	4	-	1	-	-	1	-	1	-	1	40.0
20	уурхай эзэмшигч компаниуд	14	-	-	1	1	2	-	5	-	5	20.0
21	Нартам	5	-	4	1	-	-	-	-	-	-	86.0
22	БТЕГ	4	-	-	-	-	-	-	2	-	2	0.0
	Нийт	390	105	74	48	59	23	4	12	26	39	74.5

Сайдын 2012 оны 1, 2013 оны 5, 2014 оны 6, 2015 оны 70 тушаал хэрэгжиж дуусаагүй хяналтад байгаагаас 13 нь байнгын хяналтад байх дүрэм, журам, загвар, зөвлөмж баталсан тушаал, 6 нь дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталсан, 21 нь байнгын болон түр ажиллагаатай хороо, ажлын хэсэг, комисс томилсон тушаал байна.

Зам, тээврийн яам бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орж, Зам, тээврийн хөгжлийн яам болсон, мөн ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нар нь ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотой шинэчлэн байгуулах шаардлагатай ажлын хэсгүүдийн талаарх саналыг ТЗУГ-т хүргүүлсэн.

Сайдын тушаалын биелэлтэд 2016 оны I улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжээгүй болон биелэлтээ ирүүлээгүй 45 үүрэг даалгаврын 23 нь БТГ-т өгөгдсөн үүрэг даалгавар байсан бол жилийн эцсийн байдлаар 3 болж буурсан сайн үзүүлэлттэй байгаа боловч байнга хугацаа хоцроодог, дахин дахин шаардуулдаг хэвээр

байна. Мөн УБТЗ ХНН, МИАТ ХК, НТОЗШША сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтээ ирүүлэхгүй хэвээр байна. Бусад байгууллага, газар, хэлтсүүд тайлан мэдээгээ цаг хугацаанд нь ирүүлдэг боловч бүрэн бус тайлагнадаг, хуучин оны тушаалуудын биелэлт дээр нэмж хийгдсэн ажлыг бичдэггүй, байнга буцаж холбогдон тодруулах шаардлагатай болдог дутагдал давтагдсаар байна.

Тайлан мэдээ бичих ажилд мэргэжилтнүүд хайхрамжгүй ханддагаас монгол хэлний зөв бичих дүрмийн алдаатай, утга найруулга муу, ойлгомжгүй, албаны бус хэллэгээр бичигдсэн, хуучин мэдээ, баримттай тайлан ирж байна. Иймээс тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал зөвлөмж өгөхөд биш тайланг засч найруулахад гол анхаарлаа хандуулахад хүрч байна.

Санал, зөвлөмж:

1. Газар, хэлтэс, харьяа байгууллагууд хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн болон удаашралтай хэрэгжиж байгаа (ялангуяа 2012-2015 оны) үүрэг даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах;
2. Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ажлаас чөлөөлөгдсөнөөс тухайн ажлын хэсгийн ажил удааширч хугацаа алдах тохиолдол гарч байгаа тул асуудал хариуцсан мэргэжилтэн чөлөөлөгдсөн тохиолдолд тухай бүр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж байх, байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх;
3. Тушаалын биелэлтийг тайлагнах үед харьяа байгууллага, яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүд өөрт холбоотой тушаал шийдвэр гарсныг мэдээгүй гэх гомдол байнга гарч байгаа тул тушаал боловсруулан гаргасан ажилтан тухайн тушаалаар үүрэг өгөгдсөн байгууллага, албан тушаалтанд тушаалыг “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу албан ёсоор хүргүүлж хэвших, ТЗУГ-аас хяналт тавьж ажиллах;
4. Тухайн асуудлыг хариуцсан газар, хэлтсүүд нь байхад дахин ажлын хэсэг байгуулж, үүрэг өгч байгаа нь олон газар, хэлтсийн дунд ажил цалгардуулах талтай байгаа тул онц шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулж байх;
5. Хэрэгжүүлэх боломжгүй болсон, ач холбогдлоо алдсан тушаалуудыг хүчингүй болгох;
6. Тодорхой хугацаа зааж үүрэг даалгавар өгч гаргасан тушаал цөөн байгаагаас хэрэгжилтийн явцад үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байгаа тул тушаалд тухайн үүрэг даалгаврыг ямар хугацаанд хэрэгжүүлж дуусгахыг заавал тусгаж байх;
7. Тайлан мэдээгээ цаг хугацаанд нь бүрэн ирүүлэх, үнэн зөв, алдаагүй тайлагнах талаар газар, хэлтсийн дарга нар мэргэжилтнүүдэд үүрэг даалгавар өгч, хяналт тавих, ийм алдаа дутагдал дахин гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллах;

Зөвшөөрсөн:

ЗТХЯ-ны ТНБД

Ж.Бат-Эрдэнэ

Хянасан:

ХШҮДАГ-ын ДҮТОГ

Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Баярмаа